



ТӨВ АЙМГИЙН
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/427

Зуунмод

Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллого
явуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.5 дах заалт, аймгийн Засаг даргын 2022 оны А/645 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зуунмод сумын хэмжээнд Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг 2022 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 12 дүгээр сарын 20-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2. Сумын хэмжээнд Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогын ажлын хэсгийг 1 дүгээр, ажлын удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус батласугай.

3. Багийн Засаг дарга нарт ДААЛГАХ нь:

3.1 “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл хийх журам”-тай танилцаж өөрийн хариуцсан нутаг дэвсгэрт ажлын хэсэг байгуулж, тооллого судалгааны ажлыг зохион байгуулах,

3.2 “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл хийх журам”-ын хавсралтаар батлагдсан маягтын дагуу өрх айл бүрээр судалгааг үнэн бодитой гаргах.

3.3 Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогын ажлыг заасан хугацаанд чанартай зохион байгуулж, үр дүнг тооцон, тайлан мэдээг ажлын хэсэгт хүргүүлэх.

4. Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогын, үр дүн тайлан мэдээг нэгтгэн холбогдох газарт хүргүүлэхийг Ажлын хэсгийн ахлагч (С.Мөнх-Амгалан)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Энхсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА


Ч.САРАНГЭРЭЛ



Zahiramj-2022-2

4122050978

Сумын Засаг даргын 2022 оны 11 дүгээр
сарын 17 ны өдрийн 11 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт



**АГААР БОХИРДУУЛАГЧ ЭХ ҮҮСВЭРИЙН ТООЛЛОГО
ЯВУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ**

Сумын хэмжээнд агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллого явуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн ахлагч

С.Мөнх-Амгалан

-Захирагчийн ажлын албаны ахлах мэргэжилтэн

Нарийн бичиг

О.Одням

-Байгаль орчны мэргэжилтэн

Гишүүд

Э.Гэрэлцогт

-Аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний газрын дарга

Б.Туул

Номт багийн Засаг дарга

Н.Мөнх-Өнөр

Ланс багийн Засаг дарга

Ш.Цэндсүрэн

Баянхошуу багийн Засаг дарга

Ч.Одончимэг

Зүүндэлгэр багийн Засаг дарга

Р.Баярсайхан

Нацагдорж багийн Засаг дарга

Б.Отгонбаяр

Баруун-Зуунмод багийн засаг дарга

___оОо___